

Ì Î Í Ã Ë
Ó Õ Ñ

Ì Î Í Ã Ë Ó Õ Ñ Û Ü
Ý Þ ÿ ã è é í
õ ó ö è é í
ø ñ ñ è é í
ò à ë à à ð ò ñ à í à ë,
ç à â ë à ì æ

AMNESTY
INTERNATIONAL



Эмнести Интернэшнлийн хэвлэл

Анхны хэвлэлт 2009 он
Эмнести Интернэшнлийн хэвлэл
Олон Улсын Нарийн Бичгийн Дарга нарын Газар
Петер Бененсоны байр
Ийстоны гудамж 1
Лондон WC1X 0DW
Их Британи
www.amnesty.org

□ Copyright Amnesty International Publications 2008

Индекс: ASA 30/001/2009

Эх хэл : Англи

Printed by Amnesty International, International Secretariat, United Kingdom

Бүхий л эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү хэвлэлийн ямар нэгэн хэсгийг хэвлэгчээс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр дахин хэвлэх, шилжүүлэх, засч хадгалах, ямар нэгэн хэлбэрээр буюу цахим, механик, фото хэлбэрээр, бичлэг хийх бусад хэлбэрээр аливаа зорилгоор ашиглахыг хориглоно.

Үй и андө Ей оади үө и ө ү ози өө үдөөег
хамгаалахын төлөө өаи и аи өо аажил үаооөää
150 аадоө өөн орны 2.2 наяү ози өөа үаи үүи аүү
и үаоаүйүи аүө өөө и өөөөөи өо ао өао и юм.
Аөаи өө чи дөөө аи ө ози аүд Ози өө үдөөөи
өзүйүи үө оои оааөаө аи өи и и өи и өөнү и
өзи өө үдөөөи аоннаа аадөи өаө-аүүаүа
ааоаөаааааи аүдөө ө үдөүү үаөүө үаааө
билээ. Аөа ози өө үдөөөи цо д-өөөа
адөөааоаад нóaаөө, өаи и аи өо ааөү а чи өөи и
ааөаооөө, цо аөө а, үаи үүүйү о дөо өа ааөи а.
Үй и андө өи оади үө и ө ү өөөааа чаһаөөи
ааөаө, өөн ө өөөи үи ад и үаи үүө ноддөө,
үаөөи чаһаөөи аө өаһи и өдөи ө, ө аө и ү үүө
ноддөөааһи аи аө, аөа аааи и дөаи а. Аөаи өө
үөө өөөөаааа и ү өөүа-өүи аөө үүаөөи
аүй аөүа аи өи и өаи өөаааһи һаи өүүааүа р и .

AMNESTY
INTERNATIONAL



ГАРЧИГ

I. Төслийн талаархи дэмжүүштэй асуудлууд	6
II. Цаазаар авах ялыг халах явдал хэрэгжихгүй байна	6
III. Хүний эрхийн зөрчлүүдэд ял шийтгэлгүй өнгөрөхийн эсрэг хамгаалалт тогтоохгүй байна.....	7
(i) Хуулийн төсөлд тусгагдаагүй олон улсын эрх зүйн дагуух гэмт хэргүүд .	8
(ii) Олон улсын эрх зүйн дагуу дэлхий нийтэд хянан шийдвэрлэх гэмт хэргийн харъяаллыг монгол улсад хязгаарласан нь .	11
(iii) Гэмт хэрэг хэзээ үйлдэгдсэнээс үл хамааран Олон улсын эрх зүйн дагуу яллагдаагүй гэмт хэргүүдийг Монгол Улсын шүүх хянан шийдвэрлэх боломжгүй байгаа нь.....	13
(iv) Олон улсын эрх зүйн дагуу даргын тушаал, захирагчийн үйл ажиллагаанаас үүдсэн гэмт хэргүүдэд хариуцлага тооцохгүй байгаа нь.	14
(v) Олон улсын эрх зүйн дагуу даргын тушаалыг биелүүлсэн гэмт хэргийн гүйцэтгэгчийг гэм буруугаас чөлөөлөхгүй байх хамгаалалтыг баталгаажуулж өгөөгүй нь	15
(vi) Олон улсын эрх зүйн дагуух гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоохыг хориглож чадахгүй байна.....	16

Дүгнэлт

4 ì í ā ē Ōēñ
Ýð¿¿æéí òóóééí ð°ñééí òàèààððè ñáí àè, ç° àè°í æ¿¿ä

МОНГОЛ УЛС: МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХИ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

“Эмнести Интернэшнл нь хууль тогтоогчдод цаазаар авах ялыг халах талаар болон олон улсын эрх зүйн дагуух гэмт хэргүүдэд ял шийтгэлгүй өнгөрөх явдлын эсрэг хамгаалалт тогтоохыг уриалж байна.”

Энэхүү баримт бичгээр, Эмнести Интернэшнл нь “Монгол Улсын Төрөлжсөн Эрүүгийн хуулийн төсөл”(Хуулийн төсөл)-ийг хянаж, нэмэлт, өөрчлөлт оруулах талаархи санал, зөвлөмжийг гаргаж байна.¹

Зарим нааштай хандлагуудыг үл харгалзан, Эмнести Интернэшнлийн зүгээс Хуулийн төсөл нь зарим гэмт хэргүүдийн хувьд цаазаар авах ялыг хадгалж үлдсэнд шүүмжлэлтэй хандаж байгаа бөгөөд олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцогдох хүний эрхийн зөрчлүүдийг үндэсний шүүх яллаж, мөрдөн шалгаж чадна гэдгийг баталгаажуулах үүргээ Монгол Улс хэрэгжүүлж чадахгүй байна хэмээн үзлээ. Үүнд: геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, эрүү шүүлт, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох.

Манай байгууллага нь Олон улсын эрүүгийн шүүхийг үүсгэн байгуулагч, дэмжигч Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын Дүрмийн анхдагч 60 улсын нэг болох Монгол Улс нь Ромын дүрмийг соёрхон баталснаасаа хойш 7 жил өнгөрсөн ч Олон улсын эрүүгийн шүүхтэй хамтран ажиллах гэрээний дагуу үүргээ биелүүлэхгүй байгаад санаа зовиож байна. Олон улсын эрүүгийн шүүхээс эрэн сурвалжилж байгаа, олон улсын шүүх ажиллагаанаас оргон зугатсан оргодлуудын хувьд орогнох аюулгүй газар нь байх ёсгүй гэсэн нэн тэргүүний хамтын ажиллагааны үүргээ Монгол Улсыг яаралтай биелүүлэхийг тус байгууллага уриалж байна. Монгол Улс хамтын ажиллагааны үүргээ үр дүнтэйгээр биелүүлнэ гэдгийг баталгаажуулахын тулд Олон улсын эрүүгийн шүүхийн дархан эрх ямбын тухай гэрээг мөн соёрхон батлах хэрэгтэй билээ.

¹ Төслийн Англи хэл дээрхи хувилбар энэ хугацаанд хэвлэгдээгүй байсан учир Эмнести интернэшнл нь албан бус орчуулга болон үндэсний хуулийн зөвлөх, шинжээч нарын зөвлөгөөг авч гаргасан болно. Хуулийн төслийн гол хэсгүүдийн албан бус орчуулгад тодруулах зорилгоор ишлэлүүд орсон болно.

Энэхүү баримт бичгийн дагуу Эмнести Интернэшнл нь уг хуулийг батлахын өмнө зохих нэмэлт өөрчлөлт хийхийг хууль тогтоогчидод зөвлөж, хуулийн төсөлд байгаа дутагдалыг тодорхойлж байна.

I. ТӨСЛИЙН ТАЛААРХИ ДЭМЖҮҮШТЭЙ АСУУДЛУУД

Уг хуулийн төсөлд хүлээн зөвшөөрөхүйц, магтууштай хандлагууд байгааг Эмнести Интернэшнлийн зүгээс сайшаамаар байна. Нэгдүгээрт, уг хуулийн төсөлд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийн дагуу ял шийтгэгдэх терроризм, геноцид, хүчин, дээрэм болон хорлон сүйтгэх зэрэг гэмт хэрэг дэх цаазаар авах ялыг хассан байна. Хоёрдугаарт, хуулийн төсөлд энх тайван ба хүн төрөлхтний аюулгүй байдлын талаархи бүлэг, төрлөөр устгах гэмт хэрэг зэрэг орсон байна. Гуравдугаарт, хуулийн төсөлд хүний эрхийн зөрчлүүдийг шударгаар шийдвэрлэхэд садаа болох зарим уламжлалт заалтыг хассан байна. Ялангуяа, эрүүгийн бүхий л харилцаанаас хамгаалах хамгаалалт болсон дархан эрхийн асуудлыг хасч, хууль, шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй байх зарчмыг баталгаажуулжээ.² Хуулийн төсөл нь мөн геноцид зэрэг хүн төрөлхтөн, энх тайвны аюулгүй байдлын хамгаалалтын талаархи бүлэгтээ тодорхой хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхийг хориглосон байна.³

II. ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ ЯВДАЛ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙГАА НЬ

Ял шийтгүүлж болох зарим гэмт хэргийн хувьд цаазаар авах ял хасагдсан байсныг үл тооцвол, Эмнести Интернэшнл нь бүхий л гэмт хэргүүдэд цаазаар авах ялыг уг хуулийн төсөл хориглож чадаагүйд эмзэглэж байна. Хуулийн төсөлд хоёр гэмт хэрэгт цаазаар авах ялыг оногдуулж байна 1. хүнийг санаатай алах, 2. Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах гэмт хэрэг. Энэ нь хэрцгий ширүүн, хүнлэг бус байдлаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг хүн төрөлхтний зарчмуудыг заасан хуулийн төслийн 7 дахь хэсэгт орсон чухал хэсгийг дээрхи санаа нь үгүйсгэж байна.⁴

Эмнести Интернэшнл нь цаазаар авах ялыг гүйцэтгэж байгаа арга хэрэгсэл, гэмт хэрэгтний хувийн болон гэмт хэргийн шинж чанараас хамааралгүйгээр

² 5.1 дэх заалтад зааснаар: Гэмт хэрэг үйлдсэн этгээд хуулийн өмнө эрх тэгш байх бөгөөд түүний хүйс, арьсны өнгө, хэл, үндэс угсаа, эд хөрөнгийн болон албан тушаалын байдал, оршин суугаа газар, шашин шүтлэг, итгэл үнэмшил, боловсрол зэргийг үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

³ 71.5: Энэхүү Төрөлжсөн хуулийн 326, 329, 330, 331 дүгээр зүйлд заасан Хүн төрөлхтөн, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй.

⁴ 7 дугаар зүйлд зааснаар: Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэх эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээ болон ял шийтгэл нь бусдын бие махбодийг зовоох ба хүний нэр хүндийг гутаах зорилгыг агуулж болохгүй.

бүх хэргүүдэд цаазаар авах ял хэрэглэхийг эсэргүүцэж байна. Энэ ял шийтгэл нь хүний эрхийг туйлын байдлаар үгүйсгэж байгаа юм. Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүлээн зөвшөөрсөн амьд явах эрхийг зөрчиж, ялыг дордуулсан, хүнлэг бус, хэрцгий явдал юм. Дэлхийн улсуудын гуравны хоёроос илүү нь хуулиндаа болон практикт цаазаар авах ялаас татгалзаад байна.⁵

2007 оны 12 дугаар сарын 18-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей нь дэлхийн нийтээр уг ялын гүйцэтгэлийг хойшлуулахыг уриалж, 62/149 тоот шийдвэрийг батлан гаргасан байна. Энэхүү шийдвэрийг НҮБ-ын 104 гишүүн улсын дэмжлэгээр баталж, 54 улс эсэргүүцэж, 29 улс түдгэлзсэн. 2008 оны 12 дугаар сарын 18-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей нь цаазаар авах ялыг хэрэглэх явдлыг хойшлуулахыг уриалж, хоёр дахь шийдвэрээ гаргасан. Шийдвэрийн төсөлд 106 орон дэмжсэн санал өгч, 46 нь эсэргүүцэж, 34 нь түдгэлзсэн байна. Энэхүү шийдвэрийг дэмжих дэмжлэг нэмэгдсэн нь цаазаар авах ялыг халах явдал дэлхий нийтийн хандлагыг харуулах цаашдын нотолгоо билээ.

Зөвлөмж 1: Эмнести Интернэшнл нь Монгол Улс дахь бүхий л гэмт хэргүүдийн хувьд цаазаар авах ялыг халах талаар хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахыг хууль тогтоогчдод уриалж байна.

III. ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛҮҮДИЙГ ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ӨНГӨРӨӨХИЙН ЭСРЭГ ХАМГААЛАЛТ ТОГТООХГҮЙ БАЙНА.

Ойрын жилүүдэд, Монгол Улс олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцогдох хүний эрхийн зөрчлүүдэд ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг эцэс болгох чухал алхмыг хийсэн. Үүнд:

- 2002 оны 1 дүгээр сарын 24-нд Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийг соёрхон баталсан.
- 2002 оны 4 дүгээр сарын 11-нд, Монгол Улс төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах нэн тэргүүний үүргийг хүлээсэн үндэсний шүүхтэй байх зорилгоор Ромын дүрмийг соёрхон баталсан.
- 2007 оны 2 дугаар сарын 6-нд Монгол Улс нь Хүчээр сураггүй алга болгохоос бүхий л хүмүүсийг хамгаалах тухай Олон улсын конвенцид гарын үсэг зурсан.

Монгол Улс нь түүнчлэн Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай (Геноцидын конвенц) 1948 оны

⁵ Илүү мэдээлэл авахыг хүсвэл, уг хаягаар орно уу: <http://www.amnesty.org/en/death-penalty/abolitionist-and-retentionist-countries>

конвенц, 1949 оны Женевийн конвенцууд болон 1977 оны хоёр нэмэлт протоколын гишүүн улс юм.

Эдгээр гэрээг соёрхон баталсан учир Монгол Улс нь төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, эрүүдэн шүүх болон хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдийг олон улсын эрх зүйн хатуу шаардлагын дагуу үндэсний хуулиараа гэмт хэрэг хэмээн тодорхойлон, шүүхээр хянан шийдвэрлэхээр баталгаажуулан оруулах үүрэгтэй. Нэмж хэлэхэд, хууль бусаар ял гүйцэтгэх талаар тодорхой конвенц байхгүй боловч Монгол Улс нь ялыг гүйцэтгэх, арбитрын болон хууль бус гүйцэтгэлээс урьчдлан сэргийлэх, мөрдөн байцаах тухай НҮБ-ын зарчмуудын дагуу үндэсний хууль тогтоомждоо энэхүү гэмт хэргийг оруулах нь зүйтэй.⁶

(I) ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАГДААГҮЙ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ДАГУУХ ГЭМТ ХЭРГҮҮД

Эмнести Интернэшнл нь Монгол Улс ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг эцэс болгох зорилготой гол гэрээнүүдийг соёрхон баталж, хатуу байр суурийг олсныг үл харгалзан, хуулийн төсөлд олон улсын эрх зүйн дагуу төрлөөр устгах гэмт хэргээс бусад гэмт хэргийг оруулаагүй явдалд харамсч байна.

Түүнчлэн, хуулийн төсөлд төрлөөр устгах гэмт хэргийн тодорхойлолт нь Геноцидын конвенц болон Ромын дүрэмд заасан тодорхойлолттой нийцэхгүй байгаа юм. Тодруулбал: “бүлгийн гишүүдэд бие махбодийн болон оюун санааны хувьд ноцтой хохирол учруулах”-ыг хориглосон хэсэг нь хуулийн төслийн 330 дугаар зүйлд бүрэн дүүрэн тусгагдаагүй бөгөөд оюун санааны хохирлыг үл харгалзан зөвхөн бие махбодийн хувьд хохирол учруулах үйлдэл гэж тайлбарласан нь хангалттай бус байна.⁷ Цаашилбал, “төрлөөр устгах

⁶ 1 дүгээр зарчимд зааснаар: “Засгийн газар нь бүхий л хууль бусаар, дур мэдэн, олноор нь цаазлах явдалд хууль тогтоомжоор хориг тогтооно. Ингэхдээ ийм цааз нь эрүүгийн хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэгт тооцогдож, энэ хэргийн ноцтой байдлыг харгалзан зохих ял шийтгэл оногдуулж байх нөхцлийг хангана.

Онцгой нөхцөл байдлууд, түүний дотор дайны байдал, дайны аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал болон улс орны доторх бусад онцгой нөхцөл байдал нь хууль бусаар, дур мэдэн, олноор нь цаазлахыг зөвтгөх үндэслэл болохгүй. Ямар ч нөхцөл байдал, түүний дотор дотоодын зэвсэгт мөргөлдөөн, төрийн албан тушаалтан болон албан ёсны шинж чанартай үйл ажиллагаа явуулж байгаа этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт буюу дуу гаргахгүй байх замаар зөвшөөрсний дагуу өөр этгээд хууль бусаар хүч хэрэглэж байгаа нөхцөлд ч ингэж цаазаар авахыг хориглоно. Энэхүү хориг нь гүйцэтгэх засаглалаас гаргаж байгаа тогтоолуудаас давуу шинж чанартай.”

1989 оны 12 дугаар сарын 15-ны Ерөнхий ассамблейн 44.159 дүгээр шийдвэрээр дэмжсэн, Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1989 оны 5 сарын 24-ний өдрийн 1989/65 шийдвэрээр зөвлөмж болгосон.

⁷ Хуулийн төслийн 330 (1)-д заахдаа: “Үндэстэн, угсаатан, арьсны өнгө буюу шашны бүлгийн гишүүдийг алсан, тэдгээрийн эрүүл мэндэд хүнд гэм хор учруулсан/нэмэлтийг

гэмт хэргийг шууд болон олон нийтийн өдөөн хатгалга” гэсэн нэмэлт гэмт хэрэг нь хуулийн төсөлд тусгагдаагүй байна.

Эмнести Интернэшнл нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид тусгагдсан тодорхойлолтын дагуу хуулийн төсөлд эрүүдэн шүүх гэмт хэргийг төдий л сайн тодорхойлж чадаагүйг онцолж байна. Эмнести Интернэшнлийн 2008 оны жилийн тайланд “эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаа цагдаагийн байгууллага, шорон болон баривчлан хорих газарт ихэвчлэн илэрдэг” гэж мэдээлсэн”⁸ Цаашилбал уг илтгэлд, “прокурор, хуульчид шүүхийн эрх мэдлийн хүрээнд эрүүдэн шүүхийг хориглохтой холбоотой олон улсын хэм хэмжээг мэдэх явдал дутагдалтай” байгааг тодорхойлсон байна. Хуулийн төслийн 112 дугаар зүйлд “Тарчлаах” гэмт хэргийг тодорхойлсон. Гэмт хэргийн боломжит элемент гэж эрүүдэн шүүхийг хүлээн зөвшөөрсөн заалт байгаа боловч эрүүдэн шүүх гэдэг ойлголтыг өөрийг нь хуулийн төсөлд тодорхой гэмт хэрэг гэж тодорхойлоогүй байгаа юм. 112 дугаар зүйлийн тайлбар нь “ял шийтгэл болон бусад зорилгоор бие махбодийн, оюун санааны гэм хор учруулах болон тэдний хүсэл сонирхолын эсрэг ямар нэгэн үйл ажиллагаа явуулах, мэдүүлэг гаргуулахаар албадах” гэх зорилгоор л эрүүдэн шүүх явдлыг тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид заасан тодорхойлолтоос нэлээд явцуу болжээ. Тухайлбал, төсөлд “ялгаварлан гадуурхах ямар нэгэн шалтгаанаар” тарчлаан зовоох эсвэл ноцтой өвчин шаналал үүсгэх гэх үйлдлийг хассан байна. Түүнчлэн, төрийн албан хаагчдын хариуцлагыг тодорхойлж чадаагүй байна.

Конвенцид “төрийн албан тушаалтан буюу албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүрэг хүлээнэ” гэж тарчлаах болон шаналгасаны төлөөх эрүүгийн хариуцлагыг тодорхой тусгасан.

Зөвлөмж 2: Эмнести Интернэшнл нь олон улсын эрх зүйн дагуух бүхий л гэмт хэргүүдийг үндэсний шүүхээр хянан шийдвэрлэх боломжтой гэдгийг баталгаажуулж хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахыг хууль тогтоогчдод уриалж байна.

Тодруулбал:

Төрлөөр устгах гэмт хэрэг: 330 (1) дэх зүйлд “бүлгийн гишүүдэд бие махбодийн эсвэл оюун санааны ноцтой хохирол учруулах”-ыг тодорхой хориглож, хуульд гэмт хэрэг болох төрлөөр устгах гэмт хэргийг үйлдэх, шууд

оруулах/, хүүхэд төрүүлэхэд хүч хэрэглэн саад учруулсан, хүч хэрэглэн нүүлгэн шилжүүлсэн, эсхүл энэ бүлгийн гишүүдийг бие махбодийн хувьд устгахаар тооцоолсон амьдралын бусад нөхцлийг буй болгосон нь энэ бүлгийн гишүүдийг бүрэн буюу хэсэгчлэн устгахад чиглэгдсэн үйлдэл бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.”

⁸ <http://www.amnesty.org/en/region/mongolia/report-2008>

болон олон нийтийн өдөөн хатгалгын хэлбэрийг оруулан нэмж, өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүд: Хуулийн төсөлд гэмт хэрэг гэдгээр оруулах хэрэгтэй. Ромын дүрмийн 7 дугаар зүйлд хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн тодорхойлолттой төслийн тодорхойлолт нийцсэн байх нь зүйтэй.

Дайны гэмт хэргүүд: хуулийн төсөлд дайны бүхий л гэмт хэргүүдийг оруулах хэрэгтэй. Уг гэмт хэргүүдийн тодорхойлолт нь Ромын дүрмийн 8 дугаар зүйлд заасан дайны гэмт хэргүүдийн тодорхойлолт, бусад олон улсын конвенц болон заншлын хэм хэмжээтэй нийцсэн байх хэрэгтэй. Ромын дүрэм нь Монгол Улсын Эрүүгийн хуульд оруулах шаардлагатай Женевийн конвенцууд, түүний Протоколууд, эсвэл бусад олон улсын конвенц болон заншлын хэм хэмжээнд орсон дайны бүхий л гэмт хэргүүдийг гэмт хэрэгт тооцож өгөөгүй байгаа юм. Тодруулбал, дайны гэмт хэрэгтнүүдийг шударга бусаар чөлөөлж, ялыг хойшлуулах, 1 дүгээр протоколын 85 дугаар зүйлийн 4.б-д заасны дагуу дайны гэмт хэрэг болон “ноцтой зөрчил” гэдгийг тодорхойлсон явдлыг хаасан байна. Өөрөөр хэлбэл, цэрэг зэвсэггүй бүсэд дайралт хийхийг хориглосон заалт Ромын дүрэмд гэмт хэрэг гэж тодорхой тусгагдаж өгөөгүй боловч 1 дүгээр протоколын 85 дугаар зүйлийн 3 d-д энэ харилцааг хориглож өгсөн.

Эрүүдэн шүүх: Хуулийн төсөлд тодорхой гэмт хэрэг болгон оруулах хэрэгтэй. Үүний тодорхойлолт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлтэй нийцсэн байх ёстой.⁹

Хүчээр сураггүй алга болгох: Хуулийн төсөлд гэмт хэрэг гэж оруулах хэрэгтэй. Үүний тодорхойлолт нь Хүчээр сураггүй алга болгох явдлаас бүхий л хүмүүсийг хамгаалах тухай Олон улсын конвенцын 2 дугаар зүйлтэй нийцсэн байх хэрэгтэй боловч Ромын дүрэмд зааснаар улсад бус хувь хүнд илүүтэй хандах хэрэгтэй юм.¹⁰

⁹ Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт заахдаа: ““Эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.”

¹⁰ Хүчээр сураггүй алга болгох тухай конвенцийн 2 дугаар зүйлд зааснаар: ““Хүчээр сураггүй алга болгох” гэдэг нь төрийн төлөөлөгч буюу төрийн нэрийн өмнөөс эсвэл түүний дэмжлэгтэйгээр, эсвэл түүний зөвшөөрснөөр зохион байгуулалттай буюу бие даасан этгээдүүд хүмүүсийг тэдний хүсэл бодлын эсрэг баривчлах, саатуулах, хулгайлах, эсвэл тэдний эрх, эрх чөлөөг ямар нэг байдлаар хохироох, улмаар эдгээр хүмүүсийн байгаа газрын нь тухай болон хорьж саатуулсан тухай мэдэгдэхээс

Хууль бусаар ялыг гүйцэтгэх: Хуулийн төсөлд гэмт хэрэг гэж оруулах хэрэгтэй. Үүний тодорхойлолт нь шүүх, арбитрын болон ялын гүйцэтгэлийг хууль бусаар гүйцэтгэхээс урьдчилан сэргийлэх тухай НҮБ-ын 1 дүгээр зарчимтай нийцсэн байх хэрэгтэй.¹¹

(II) ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ДАГУУ ДЭЛХИЙ НИЙТЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХАРЪЯАЛЛЫГ МОНГОЛ УЛСАД ХЯЗГААРЛАСАН НЬ

Хуулийн төслийн 12 дугаар зүйл нь Монгол Улсаас гадна үйлдэгдсэн гэмт хэргийн түгээмэл харъяаллыг хэрэгжүүлэхийг Монгол Улсын шүүхэд эрх олгосон 1961 оны Эрүүгийн хуулин дахь заалтуудыг илүү өргөн хүрээнд дахин тогтоож өгсөн боловч уг Эрүүгийн хуульд зөвхөн тодорхойгүй хязгаарлалтууд байх бөгөөд хязгаарлагдмал 2 тохиолдолд л шүүхийн харъяалал хэрэгжихээр заасан байна.¹²

Нэгдүгээрт, 12 (1) зүйл нь Монгол Улсад байнга оршин сууж буй харъяалалгүй хүмүүсийг хянан шийдвэрлэх харъяаллыг заасан.¹³

татгалзаж, тэдгээр хүмүүсийг хуулиар хамгаалах боломжгүй байдал бий болгохыг хэлнэ."

¹¹ 6 дугаар ишлэлийг харна уу. 1989 оны 12 дугаар сарын 15-ны Ерөнхий ассамблейн 44.159 дүгээр шийдвэрээр дэмжсэн, Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1989 оны 5 сарын 24-ний өдрийн 1989/65 шийдвэрээр зөвлөмж болгосон.

¹² Эдгээр заалтууд нь дэлхий нийтийн шүүхийн харъяаллын бие даасан эх сурвалжууд байх, эсвэл хууль тогтоомжийг дахин баталж болох үндсэн хуулийн хоёр заалтаар нэмэлт орж болно. Нэгдүгээрт, 1992 оны Үндсэн хуулийн 10 (3) дахь зүйлд зааснаар: '

"Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ."

Хоёрдугаарт, 10 (1) дүгээр зүйлд зааснаар: "Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна . . ." нь Монгол Улс нь Олон улсын заншлын хэм хэмжээ, Эрх зүйн ерөнхий зарчмуудад үндэслэн дэлхий нийтийн шүүхийн харъяаллыг хэрэгжүүлэх боломж байгааг харуулж байна.

¹³ Хуулийн төслийн 12.(1). Монгол улсын иргэн ба Монгол улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа харъяалалгүй этгээд энэхүү Төрөлжсөн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлын эсрэг Монгол улсын нутаг дэвсгэрийн гадна гэмт хэрэг үйлдсэн бол хэрэв түүний хувьд энэхүү гэмт хэргийн талаар гадаад улсын шүүхийн шийдвэр гараагүй бол энэхүү Төрөлжсөн хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Түүнчлэн, 1961 оны Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн б хэсгээс (хуулийн үйлчлэх хүрээ) илүү хязгаарлагдмал байна:

Хоёрдугаарт, Хуулийн төслийн 12 (3) дугаар заалтад Монгол Улсын шүүхийн эрх хэмжээг хязгаарласан байна. “Монгол Улс нэг тал нь болсон олон улсын гэрээ”-гээр гадаадын иргэдийн үйлдсэн гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг олгосон.¹⁴ Гишүүн улсууд нь гэрээнд заасан тодорхой гэмт хэргүүдэд сэжиглэгдсэн хүмүүсийг барих, яллах зорилгоор эрх бүхий байгууллагад хэргийг шилжүүлэх үүрэгтэй гэдгийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц зэрэг олон улсын эрх зүйн дагуу зарим гэрээнд гэмт хэргүүдийг тодорхой оруулж тусгасан боловч “баривчлах, эсвэл яллах” заалтууд бүхий тодорхой гэрээнд олон улсын эрх зүйн дагуу бүхий л гэмт хэргүүд ороогүй байдаг. Тухайлбал, Хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүд нь Ромын дүрэмд, төрлөөр устгах нь 1948 оны Геноцидын конвенцид орсон боловч аль ч гэрээнд нь “баривчлах эсвэл яллах” заалт байдаггүй. Олон улсын гэрээн дэх ийм хэрэг хянан шийдвэрлэх эрхийг Монгол Улс хязгаарлаж буй нь олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээгээр зарим тохиолдолд улс бүр олон улсын эрх зүйн дагуу бүхий л гэмт хэргүүдийг түгээмэл харъяаллаар тусган зохицуулалт хийх шаардлагатай болдог.¹⁵ Тийм ч учраас Монгол Улс нь тэдгээр айдас төрүүлэм гэмт хэрэг үйлдэгчдийг орогнуулах газар болохгүй гэдгийг баталгаажуулах заалтыг одоогийн хууль тогтоомждоо тусган бэхжүүлэх хэрэгтэй.

Зөвлөмж 3: Эмнести Интернэшнл нь гэмт хэрэг хэзээ, хаана үйлдэгдсэнээс үл хамааран, алагчлалгүйгээр төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдэд

“ . . . БНМАУ-ын хилээс цаана гэмт хэрэг үйлдсэн БНМАУ-д байгаа харъяалалгүй хүмүүсийг БНМАУ-ын нутаг дэвсгэрт олж илрүүлсэн тохиолдолд уг хуулийн дагуу эрүүгийн ял, хариуцлага тооцох субъект болгоно.”

1975 онд нэмэлт өөрчлөлт орсон, 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль, William E. Butler-т дахин хэвлэгдсэн, Монгол Улсын Эрх зүйн тогтолцоо: Орчин үеийн хууль тогтоомж ба баримт бичиг (The Hague/Boston/London: Martinus Nijhoff Publishers 1982), 3 (b) заалт. Энэ заалт нь шүүхийн харъяаллыг хэрэгжүүлэх Монгол Улсын шүүхийн хувьд Монгол Улсад байнга оршин сууж байгаа харъяалалгүй хүмүүст хамаарахгүй заалт юм.

¹⁴ Хуулийн төслийн 12. (3) Гадаадын иргэн ба Монгол улсад байнга оршин суугч бус харъяалалгүй этгээд Монгол улсаас гадна үйлдсэн гэмт хэрэг нь хэрэв Монгол улс, эсхүл Монгол улсын иргэн, эсхүл Монгол улсад байнга оршин амьдардаг харъяалалгүй этгээдийн ашиг сонирхлын эсрэг чиглэгдсэн, түүнчлэн Монгол улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд хэрэв гадаадын иргэн ба Монгол улсад байнга оршин суугч бус харъяалалгүй этгээд гадаад улсад ял шийтгэгдээгүй ба Монгол улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдаж байгаа бол энэхүү Төрөлжсөн хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

¹⁵ Эмнести интернэшнл, Дэлхий нийтийн шүүхийн харъяалал: Хууль тогтоомж батлах, хэрэгжүүлэх талаархи улсуудын үүрэг (AI Index: IOR 53/002-018/2001).

сэжиглэгдсэн хэн нэгнийг шүүх түгээмэл харъяаллыг Монгол Улсын шүүх хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгох тухай 12 дугаар зүйлийн хүрээг өргөтгөн хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахыг хууль тогтоогчдод уриалж байна. Эдгээр заалтууд нь шаардлагатай бол баривчлах хүсэлт, эсвэл эхэлж болох мөрдөн байцаалтын өмнөх зарим асуудалд Монгол Улсад сэжиглэгдсэн гэсэн шаардлагаар ямар нэгэн тодорхойгүй саад тоггор учруулах ёсгүй.

(III) ГЭМТ ХЭРЭГ ХЭЗЭЭ ҮЙЛДЭГДСЭНЭЭС ҮЛ ХАМААРАН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ДАГУУ ЯЛЛАГДААГҮЙ ГЭМТ ХЭРГҮҮДИЙГ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙГАА НЬ

Эмнести Интернэшнл нь Хуулийг батлахаас нь өмнө төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдийг мөрдөн байцаах, яллахыг хориглож болох хуулийн төслийн 9, 10 дугаар заалтуудад шүүмжлэлтэй хандаж байна.¹⁶ Хэдийгээр эрх зүйн зарчмын дагуу хуулиар гэмт хэрэгт тооцоогүй бол гэмт хэрэг гэж үзэхгүй боловч тэдгээр гэмт хэргүүд нь хэдэн арван жилийн турш олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн эрх зүйн нийтлэг зарчмуудын дагуу гэмт хэрэгт тооцогддог. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 15(2) дугаар зүйлд “хэрэг үйлдэх үед олон улсын хамтын нийгэмлэгийн хүлээн зөвшөөрсөн эрх зүйн ерөнхий зарчмын дагуу эрүүгийн гэмт хэрэгт тооцож байсан үйлдэл буюу эс үйлдэл хийсэн этгээдийг шүүхэд шилжүүлэх болон шийтгэхэд энэ зүйлийн заалт саад болохгүй” гэж заасан нь илүү тодорхой болгож байна.

Зөвлөмж 4: Эмнести Интернэшнл нь төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдийг хэзээ үйлдэгдсэнээс үл хамааран Монгол улсын шүүх хянан шийдвэрлэх харъяаллыг баталгаажуулах талаар хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хууль тогтоогчдод уриалж байна.

¹⁶ Хуулийн төслийн 9.1 дүгээр зүйлд: Гэмт хэрэг ба ял хүлээх хэргийг тухайн хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан эрүүгийн хуулиар тодорхойлно.

Нэмж хэлэхэд, 10.1 дүгээр зүйлд: Хэргийг гэмт хэрэгт тооцохгүй болсон, ял хөнгөрүүлсэн буюу бусад байдлаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн байдлыг дээрдүүлсэн эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх бөгөөд өөрөөр хэлбэл, ийм хууль батлахаас өмнө холбогдох хэрэг үйлдсэн, түүний дотор ял эдэлж байгаа, ял эдэлж байсан буюу ялтай байдалтай байгаа этгээдэд хамаарна. Хэргийг гэмт хэрэгт тооцсон, ялыг чангатгасан буюу өөр байдлаар тухайн этгээдийн байдлыг дордуулсан эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй.

10.2: Хэрэв эрүүгийн шинэ хуулиар тухайн этгээдийн ял эдэлж буй хэрэгт заасан ялыг хөнгөрүүлж байгаа бол шинэ эрүүгийн хуульд заасан хязгаарын хүрээнд түүний ялаас хасна

(IV) ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ДАГУУ ДАРГЫН ТУШААЛ, ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮДСЭН ГЭМТ ХЭРГҮҮДЭД ХАРИУЦЛАГА ТООЦОХГҮЙ БАЙГАА НЬ.

Хуулийн төсөлд, олон улсын эрх зүйн дагуу цэргийн командлагч, цэргийн командлагчийн үйл ажиллагаа явуулсан захирагч этгээд болон иргэний удирдлагад хүлээлгэх хариуцлагын талаар ямар ч заалт тусгагдаагүй байна.¹⁷ Хуулийн төсөлд ийм заалт орхигдсон байгаа нь төслийн 4.1 дэх гэм буруугийн зарчмын дагуу гэмт хэрэг үйлдсэн хүн бүр өөрт тохирсон ял шийтгэлийг хүлээх зарчимтай зөрчилдөх буюу гэмт хэрэг үйлдсэн этгээд зарим нөхцөлд ял шийтгэлгүйгээр өнгөрч болох шалтгаан болж, тэдэнд ял шийтгэл хүлээлгэх, урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авах боломжгүй болж байна. Түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн, түүний удирдлагад нь байдаг хүмүүсийн гэмт хэргийг мэдсэн, мэдэх боломжтой байсан захирагч, удирдагчдад хариуцлага хүлээлгэх хууль зүйн боломжгүй байгаад Эмнести Интернэшнл шүүмжлэлтэй хандаж байна.¹⁸ Цэргийн командлагч болон цэргийн командлагчийн үйл ажиллагаа явуулсан этгээдүүдэд зориулсан тодорхой стандарт тогтоох хэрэгцээ шаардлага нь олон улсын дийлэнхи бичиг баримтад тусгагддаг¹⁹ бөгөөд Ромын дүрмийн ихэнх гишүүн улсууд хэрэгжилтийг нь хууль тогтоомждоо зааж, баталгаажуулсан байна. Түүнчлэн, Монгол Улсын хувьд Женевийн конвенцийн 1 дүгээр протоколын дагуу үндэсний хууль тогтоомждоо тэдгээр заалтыг тусгах шаардлагатай байгаа юм.

Зөвлөмж 5: Эмнести Интернэшнл нь хуулийн төсөлд удирдлага болон захирагчийн хариуцлагын талаархи тодорхой заалтууд нэмж оруулахыг хууль тогтоогчидод уриалж байна. Эдгээр заалт нь юуны өмнө дараахь шинжийг агуулсан байх хэрэгтэй. Үүнд:

- ***Цэргийн командлагчид болон иргэний удирдагч нарт нэгэн адил тэгш хамаарах заалт;***

¹⁷ Удирдлага болон захирагчийн хариуцлагын хүрээний хувьд, Эмнести Интернэшнл болон Олон улсын эрүүгийн шүүхийн Эрхийн сонголт гаргах тулаархи 1 дүгээр хэсгийг үзл (AI Index: IOR 40/001/1997), Түүнчлэн Олон улсын эрүүгийн шүүхийн прокурор Jean-Pierre Bemba Gombo-д ирсэн Захирагчийн хариуцлагын талаархи сануулгыг үзнэ үү. ICC-01/05-01/08, 20.04.2009, <http://www.icc-cpi.int/iccdocs/doc/doc669669.pdf>

¹⁸ Хуулийн төслийн 4 (1): “Зөвхөн нийгэмд аюултай үйлдэл (эс үйлдэхүй) үйлдсэн ба нийгэмд аюултай хор уршиг учруулсан, тэдгээртэй харьцсан гэм буруу нь тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”

¹⁹ Жишээ нь: Женевийн конвенцийн 1977 лны 1 дүгээр протоколын 86 (2) дахь заалт, Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргийн хуулийн 1996 оны төслийн 6 дугаар зүйл, Руандагийн Олон улсын эрүүгийн шүүхийн 1994 оны дүрмийн 6.3 дахь заалт, Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүхийн 1993 оны дүрмийн 7(3) дахь заалт болон Сиерра Лионы Тусгай шүүхийн дүрмийн 6(3) заалт.

- **Захирагч болон удирдагч нь удирдлагандаа байдаг хүмүүсийг гэмт хэрэг үйлдсэн, үйлдэж байсан талаар мэдсэн, мэдэх боломжтой байсан,**
- **Захирагч болон удирдагчийн эрх мэдлийн хүрээнд боломжит бүхий л арга хэмжээг (зайлшгүй шаардлагатай бүхий л арга хэмжээ) дарга, удирдагч нь авч чадаагүй.**
- **Захирагч болон удирдагч нь удирдлагадаа байдаг этгээдийг шийтгэж, урьдчилан сэргийлж чадаагүй.**

(V) ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ДАГУУ ДАРГЫН ТУШААЛЫГ БИЕЛҮҮЛСЭН ГЭМТ ХЭРГИЙН ХУВЬД ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ГЭМ БУРУУГААС ЧӨЛӨӨЛӨХГҮЙ БАЙХ ХАМГААЛАЛТЫГ БАТАЛГААЖУУЛЖ ӨГӨӨГҮЙ БАЙНА

Хуулийн төслийн 42 дугаар зүйлийн дагуу заавал биелүүлэх даргын тушаалын дагуу төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргийг үйлдсэн нь түүнийг гэм буруугүй хэмээн үзнэ гэх заалтад шүүмжлэлтэй хандаж байна.²⁰ Энэ нь тэд хууль бус тушаал гэдгийг мэдээгүй байсан хэмээн өөрийгөө хамгаалах боломжийг үүсгэх юм. Олон улсын эрх зүйн дагуу ийм ноцтой гэмт хэрэгт буруутгагдсан этгээдийн хувьд энэ нь боломжгүй байх ёстой. Нюренбергийн конвенцийн 8 дугаар зүйлд зааснаар олон улсын заншлын хэм хэмжээ нь хэдийгээр даргын тушаалыг биелүүлсэн боловч түүнийг гэм буруугаас чөлөөлөхгүй байх хамгаалалтыг үгүй болгож байна:

‘Хариуцагч нь өөрийн Засгийн газрын шийдвэр, эсвэл даргын тушаалын дагуу ажилласан үйлдэл нь хариуцлагаас түүнийг чөлөөлөхгүй боловч шаардлагатай гэж шүүх хурлаас үзвэл шийтгэлийг багасгаж болно.’

Хуучин Югослав, Руанда болон Сиерра Леон улсууд дахь тусгай шүүхийн

²⁰Хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.1-д: Заавал биелүүлэх тушаал буюу захирамжийг биелүүлсэн этгээд эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсныг гэмт хэрэг гэж үзэхгүй. Хууль бус тушаал буюу захирамж гаргасан этгээдэд ийм гэм хорын төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

42.2-т: Хууль бус тушаал буюу захирамжийг зориуд биелүүлж, гэмт хэрэг санаатай үйлдсэн этгээдэд нийтлэг үндэслэлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хууль бус тушаал буюу захирамжийг зориуд хэрэгжүүлээгүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

олон улсын эрүүгийн шүүх ажиллагааны дүрмүүдэд ижил хэм хэмжээ тусгагдсан байдаг.

Зөвлөмж 6: Эмнести Интернэшнл нь төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдийн хувьд гүйцэтгэгч нь даргын тушаалын дагуу ямар нэгэн үйлдэл хийсэн гэдэг нь түүнийг гэм буруугаас чөлөөлөх үндэслэл болж чадахгүй хэмээх агуулгатай зохицуулалтыг хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлтөөр оруулахыг хууль тогтоогчидод уриалж байна.

(VI) ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ДАГУУХ ГЭМТ ХЭРЭГТ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА ТОГТООХЫГ ХОРИГЛОЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

Эмнести Интернэшнл нь хуулийн төслийн 71.5 дахь төрлөөр устгах болон хүн төрөлхтөн, энх тайвны аюулгүй байдлын талаархи бүлэгт орсон бусад гэмт хэргүүдийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг тогтоогоогүйг санал нэгтэйгээр дэмжиж байна.²¹ Энэ нь Ромын дүрмийн 29 дүгээр зүйлд тусгагдсан “шүүхийн харъяалалд байгаа гэмт хэргүүд нь ямар нэгэн хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй” гэсэн заалттай нийцэж байна. Энэ нь Монгол Улсын соёрхон баталсан Дайны гэмт хэрэг болон Хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай конвенцтой нийцэж байна.

Зөвлөмж 7: Хуулийн төсөлд орж буй хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүд дээр нэмээд, 71(5) –д зөвхөн эдгээр гэмт хэргүүдээр хязгаарлах бус олон улсын эрх зүйн дагуух бусад гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй байх тухай нэмэлт өөрчлөлтийг оруулах хэрэгтэй юм.

ДҮГНЭЛТ

Эмнести Интернэшнлээс энэхүү Эрүүгийн төрөлжсөн хуулийн төсөлд хийсэн шинжилгээ нь хууль тогтоогчдод хандан тус хуулийг батлагдахаас өмнө түүний алдаа, дутагдалыг засаж, сайжруулахын тулд тодорхой нэмэлт, өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай болохыг тодорхойлоход чиглэгдсэн юм. Хууль тогтоогчид эдгээр зөвлөмжүүдийн талаар илүү дэлгэрэнгүйгээр ярилцахыг хүсвэл Монгол Улс дахь Эмнести Интернэшнлтэй дараахь хаягаар холбоо барина уу:

Эмнести Интернэшнл
Сүхбаатар дүүрэг

²¹ Ишлэл 3-ыг харна уу.

Бага тойруу,
6 дугаар хороо,
44 дүгээр байр, 10 тоот.
Улаанбаатар 210648
Tel: (+976) 11 324 705
E-mail: aimncc@magicnet.mn

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ЗӨВЛӨМЖҮҮДИЙН ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл нь хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахыг хууль тогтоогч нарт уриалж байна:

1. Монгол Улс дахь цаазаар авах ялыг бүхэлд нь халах.
2. Олон улсын эрх зүйн дагуу бүх гэмт хэргүүдийг үндэсний шүүхээр хянан шийдвэрлэх явдлыг баталгаажуулах, ялангуяа: төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдэд.
3. Төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдэд сэжиглэгдсэн аливаа этгээдийн хувьд үйлчлэх түгээмэл харъяаллыг Монгол Улсын шүүх хэрэгжүүлэх эрх хэмжээг олгож, 12 дугаар зүйлийн хүрээг өргөтгөх.
4. Гэмт хэрэг хэзээ үйлдэгдсэнээс үл хамааран төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдийг Монгол Улсын шүүх хянан шийдвэрлэх харъяалал байгаа гэдгийг баталгаажуулах,
5. Удирдагч, захирагчийн хариуцлагын талаар тодорхой заалтууд нэмэх.
6. Төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдийг үйлдсэн нь даргын тушаал байсан ч гүйцэтгэгчийг гэм буруугаас чөлөөлж чадахгүй гэдгийг тусгах.
7. Төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг, дайны, эрүүдэн шүүх, хууль бусаар ял гүйцэтгэх, хүчээр сураггүй алга болгох гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг тогтоохгүй байх.

□□□□□□ й □□□□□□ □□

л □□□ □□□□ □ □□□□□ □□□□□□ Дарга нарын
Г□□□□

Peter Benenson House
1 Easton Street
London WC1X 0DW

www.amnesty.org

AMNESTY
INTERNATIONAL

